

БУДДЫН ЁС СУРТАХУУНЫ СУРГААЛЫН ТУХАЙД

Б.Оюунчимэг /доктор (Ph.D), профессор/
Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль

Түлхүүр үг. Шүтэн барилдлага, онол, сургаал, үзэл санаа, ёс суртахууны шаардлага, ёс суртахууны зарчим, хэм хэмжээ, алдаа дутагдал, зан суртахуун, сэтгэлийн гэм хир, засах арга зам

***Товч утга:** Шашин мөн чанараараа ёс суртахуунтай холбоотой тул ёс суртахууныг номлож, хувь хүний болон нийгмийн ёс суртахуунд нөлөөлж байдаг. Шашин бүр ёс суртахууны тун боловсронгуй сургаалуудтай бөгөөд тэдгээрийг хүн төрөлхтөн даган мөрдсөөр иржээ. Шашиныудын сургаал хүн төрөлхтний ёс суртахууны нэгдмэл дүрмийг тогтоох, хэвшүүлэн мөрдүүлэхийг үүрэг, зорилгоо болгодог ч буддын ёс суртахууны сургаал олон зуун жилийн туршид янз бүрийн чиглэлээр тасралтгүй баяжин хөгжиж, системчлэгдэж, бүхэл бүтэн үзэл баримтлал (буддизм) болж, ёс суртахууны сургаалууд дотроос хамгийн өргөн цар хүрээтэй, өнөө цаг үед ач холбогдлоо алдах битгий хэл улам бүр дэлгэрэн хөгжиж байна. Буддын сургаалын ёс суртахууны үндэс нь хүн өөрийн муу сэтгэлүүдийг өвчин эмгэг мэтээр ойлгох явдал. Буддын сургаалд хүний амьдралын зорилгыг ёс суртахуунтай нягт холбон авч үздэг. Буддын ёс суртахууны сургаалын нэг чухал үзэл санаа нь амьдралын хоёр туйлаас зайлсхийж, дундаж зам мөрийг даган мөрдөх явдал. Дундаж зам мөр нь зөв зүйтэй, зохистой найман мөрийн нэгдэл. Буддагийн номлосон ёс суртахууны сургаалын өөр нэг үзэл санаа нь хүний дотоодод хандсан шинжтэй сэтгэлээ судлах, удирдах, хүслээ хязгаарлан номхотгох, өөрийгөө ялж сурах, биеэ зөв авч явах, зөв үйл хийх, сэтгэл санаагаа цэвэрлэн ариусгах явдал. Буддын ёс суртахууны номлолын нэг чухал хэсэг нь энэрэн нигүүлсэх сэтгэлийн тухай сургаал. Буддын шүтэн барилдлагын сургаал, түүний нэг хэсэг болох үйлийн үрийн онолд ёс суртахууны хэм хэмжээг сахин мөрдөх шаардлагын тухай номлож, бие, хэл, сэтгэлээр муу үйл хэзээ ч хийхгүй гэсэн амийг өөртөө өгч, тангараг тавьж, түүндээ хүрэх сахил, санваар сахин баримталж болно хэмээн өгүүлсэн байдаг. Сахил гэдгийг ёс суртахуун, санваарыг ёс журам гэж ойлгоно. Сахил буюу ёс суртахуун зөв, сайн бүхний үндэс.*

Шашин ёс суртахууныг номлож, хувь хүний болон нийгмийн ёс суртахуунд нөлөөлж байдаг. Энэ талаар Германы сонгодог философийн төлөөлөгч И.Кант “Шашин ёс суртахуунд үндэслэдэг”,

Австрийн сэтгэл судлаач З. Фрейд “... Ёс суртахуунлаг чанар шашинд бий” (7.1) гэж тодорхойлсон байдаг. “Шашин ёс суртахууны үндсэн зарчмуудыг бүтээхэд бидэнд тусалж чадна” (4.165)

хэмээн Дээрхийн гэгээн XIV Далай лам Данзанжамц хэлсэн нь бий. Энэ нь шашин мөн чанараараа ёс суртахуунтай холбоотой, хүн төрөлхтөн ёс суртахуунлаг байх, ёс суртахууны алдаа дутагдлаа засахын тулд шашин, түүний онол сургаалд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатайг өгүүлсэн аж.

Шашин бүр ёс суртахууны боловсронгуй сургаалуудтай бөгөөд тэдгээрийг хүн төрөлхтөн даган мөрдсөөр ирсэн (4.166). “Миний номлосон сургаал жирийн сүсэгтэнд сахин мөрдөх зүйл (ёс суртахуун), их мэргэдэд гүн ухааны үзэл баримтлал (тогтсон таалал) юм” (7.1) гэж Будда айлдсан тухай “Ланкаватара” сударт тэмдэглэсэн нь бий. Энэ санаа Нагаржунагийн бүтээлд ч тусгалаа олсон байдаг.

Буддын, христосын, исламын гээд бүхий л шашны сургаалууд хүн төрөлхтний ёс суртахууны нэгдмэл дүрмийг тогтоох, хэвшүүлэн мөрдүүлэхийг үүрэг, зорилгоо болгодог ч буддын ёс суртахууны онол сургаал шиг олон зуун жилийн туршид янз бүрийн чиглэлээр тасралтгүй баяжин хөгжиж, системчлэгдэж, бүхэл бүтэн үзэл баримтлал (буддизм) болсон нь үгүй юм.

Эртний Дорно дахинд ёс суртахуун номлодог урсгал чиглэлүүд үүсэж, онол сургаалууд бий болж байсны дотор хамгийн өргөн цар хүрээтэй, өнөө цаг үед ч ач холбогдлоо алдах битгий хэл, улам бүр дэлгэрэн хөгжиж байгаа нь буддын ёс суртахууны сургаал аж.

Будда нийт 84000 сургаал айлдсан бөгөөд тэдгээр нь хүн төрөлхтний ёс зүйн сэтгэлгээний түүхэнд томоохон

байр суурь эзэлдэг. Буддагийн сургаалын ёс суртахууны үндэс нь хүн өөрийн муу сэтгэлүүдийг өвчин эмгэг мэтээр ойлгох явдал. Будда аливаа ёс бус, муу муухай үйлдлийг нүгэл, харин эерэг зөв, сайн сайхан, шударга үнэнч, нигүүлсэнгүй бүхнийг буян хэмээн нэрлэжээ. Тэрбээр мэргэшсэн эмч адил сэтгэлийн өвчнийг тун зөв оношилж, ариун ёс суртахууныг сэтгэлийг эмчлэх эм хэмээн зааж өгчээ. “Ариун ёс суртахуунтай амьдрахаар сонгох нь биеийн өвчнийг эдгээхээр эм уухтай адил юм. Тэрхүү ариун ёс суртахууны эхлэл нь буруу үйлийг тэвчих зорилго тавих явдал. Дараагийн шат нь буруу үйлийг тэвчих амлалтыг өөртөө өгөх явдал” (2.61) гэж Будда өгүүлсэн.

Тэвчих замаар ёс суртахууны хэм хэмжээг мөрдөх (найман сахил сахих)-ийн ач холбогдлыг буддын сургаалд номложээ. Үүнд:

- **Амь хөнөөх үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд урт насалж, үзэсгэлэн төгс, өвчин зовлон багатай амьдарна.

- **Эс өгсөнийг авах үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд эд баялаг байж, хэн нэгний хорлолд өртөхгүй. Эс өгсөнийг авахгүйн тулд “би эс өгснийг авахгүй” гэсэн хатуу амлалт өөртөө өгнө. Энэ нь хүн минийх гэж тооцдог өргөг өндөртэй зүйлээс эхлээд сэтэрхий зүү, сиймхий хадаг ч авахгүй байх тухай тангараг.

- **Ариун бус үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд үзэмж төгс бие бялдартай, мэдрэхүйн эрхтнүүд бүрэн бүтэн байх болно.

- **Худал хэлэх үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд хүнд хууртагдахгүй бөгөөд хэлсэн үг бүрийг хүмүүс анхааран хүлээн авдаг болно. “Худал эс хэлэх” амлалт өөртөө өгнө. Худал эс хэлэх гэдэг нь худал хэлэхийг чанд тэвчих сахил буюу ёс суртахуун сахих, өөрийн эрдэм, чадварын талаар дэгэсдүүлж хэлэхгүй байх, тоглоомоор ч гэсэн худал ярихгүй байх ам тангараг өгөх явдал юм.

- **Мансууруулах зүйл** (архи, тамхи, мансууруулах, биеэ хянах чадвар сулруулах аливаа бодис) хэрэглэх үйлийг **тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд тогтвортой, сэрэмжтэй, ухаантай, тод мэдрэхүйтэй, билиг оюун төгс байх болно. Архи, шар айраг, дарс хэрэгснээр сэтгэл тэнцвэргүй болно, хорлолт муу үйл үйлдэх, алдаа гаргах олон нөхцөл сэтгэлийн байдлаас хамааран хурдан, эсвэл аажмаар бүрдэнэ.

- **Өндөр суудал, сэнтийд суух үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд бусдын магтаал, хүндэтгэлийг хүлээнэ, хэрэгтэй бүхэн (зөөлөн, дулаан ор дэвсгэр, амрах, цэнгэх байр, аялах унаа хөсөг г.м)-тэй байх болно. ”Би өндөр, өргөн, үнэтэй суудалд суухгүй” гэсэн сахил нь алт, мөнгө, үнэт чулуу, зандан болон эмийн модоор урласан өргөн сэнтий, гялгар торго, арслан бар, баавгай, чонын арьсаар хийсэн суудалд суухыг тэвчих тангараг юм.

- **Үнэртэн танартан хэрэглэх, чимэг зүүх үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд сайхан үнэр, өнгөтэй, галбир сайтай биетэй байх болно.

- **Зохисгүй цагт идээ зооглох үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд арвин, тэжээлт ургацтай байна, идээ ундаа бэрхшээлгүй олдоно. Зөв цагт идээ зооглоно гэдэг нь нар мандахаас үд хүртэлх хугацаанд хоол унд хүртэх явдал юм.

- **Дуулах, бүжиглэх үйлийг тэвчсэнээр** энэ хийгээд хойтын төрлүүдэд бие болон сэтгэл номхон байна, хэл үргэлж номыг өгүүлнэ. (6.56)

Буддын сургаалд хүний амьдралын зорилгыг ёс суртахуунтай нягт холбон авч үзэж, “Хүн сайхан орон гэр, хувцас хунар, хоол хүнс, эд хөрөнгө бэлдэх, гэр бүл, үр хүүхэдтэй болох, тэднийгээ өсгөн торниулах, халамжлах төдийхөнд сэтгэл ханаж, сайхан амьдарч, зорилгоо биелүүлж байна хэмээн бодож оршин тогтнох нь эрдэнэт биеийг олж, найман чөлөө учралд төрсөн хүний хувьд хангалтгүй юм. Хүн болох, жинхэнэ хүн болох, гэгээрэх зорилго тавих ёстой. Хүн болох нь оюунлаг болох, жинхэнэ хүн болох нь хүмүүнлэг, ёс суртахуунлаг болох, гэгээрэх нь муу бүхнээ орхиж, сэтгэлээ ариусах, оюунаа гэгээрүүлэх, бусдын тусын тулд өөрийгөө бүрэн зориулах явдал юм. Хүний дээд зорилго бол гэгээрэх. Гэгээрэх нь сэтгэлээ ариусгах, оюунаа гэгээрүүлэх, ёс суртахууны шаардлагыг танин мэдэх, сахин биелүүлэх, ертөнцийн юмс үзэгдлийн мөн чанарыг ухааран ойлгох аргазүйд суралцах, түүнийг эзэмших явдал юм” (2. 70,124) гэж дүгнэжээ.

Буддын ёс суртахууны сургаалын өөр нэг үзэл санаа нь амьдралын хоёр туйлаас зайлсхийх, дундаж зам мөрийг даган мөрдөх явдал. Амьдралын хоёр

туйлаас зайлсхийх гэдэг нь буруу хүсэлд автах, түүнийгээ хангах гэж элдвээр хөөцөлдөхөөс зайлсхийх, бие махбод, сэтгэл санаагаа албадан сорих, тарчлаан зовоох, хэт хатуу амьдралд шунахаас болгоомжлон сэргийлэх явдал юм.

Будда “Дундад зам мөр” хэмээх сургаалдаа хүний сэтгэл, зан суртахууны талаар номлож, “Ертөнцийн бүх шунал тачаалыг ухааны болон зүрх сэтгэлийн гэж хоёр төрөлд хуваана. Тэдгээрийн үүсэх шалтгаан нь уур хилэн, мунхаг харанхуй, шунахай сэтгэл. Харанхуй мунхаг нь үнэнийг эс ойлгох явдал, ховдог шунахай сэтгэл нь шунал амьдралд дадал болохын эх ундарга, нүдээр харсан, чихээр сонссон бүхнийг эзэгнэх хүслэн. Дундаж зам мөр нь юмсыг үзэх дундаж үзэл, амьдрах дундаж ухаан, зөв буруугийн аль алинд нь хэт дасаж төөрөлдөхөөс ангижрах чадвар. Дундаж зам мөр нь зөв зүйтэй дараах найман мөрийн нэгдэл” (2.62) хэмээн айлджээ. Үүнд:

Зөв үзэл. Энэ нь зөв зүйтэй бодол санаа юм. Зөв бодолтой байж “Дөрвөн үнэн” сургаалд итгэж, түүнийг ойлгон ухаарч байж зөв үзэлтэй болно. Зөв бодол санаатай байж сайн сайхан явна. Энэ талаар монголчууд “Санаа сайтын заяа сайн”, “Сайн санааны үзүүрт тос” гэдэг.

Зөв эрмэлзэл. Энэ нь зөв тэмүүлэл, мөрөөдөл, төсөөлөл, зорилго юм. Муу санаа агуулж бусдад дайсагнахаас эрс татгалзаж, хэзээ ямагт хайр, сайн санааг хадгалж явахыг хүсэх нь зөв эрмэлзэл. “Сайжрал дэвшил бүхний үндэс нь зөв зорилго” гэж Будда айлдсан байдаг. Хүн юунд суралцахаа урьдчилан тооцсоны үндсэн дээр хэтийн зорилгоо зөв

тодорхойлох ёстой. Эрдэм номд суралцах зорилго улам сайжирч, боловсронгуй болох гэсэн хүсэл тэмүүлээс үүсэн бий болох ёстой.

Зөв үг яриа. Энэ нь зөв эрмэлзэл, зөв үзлийн үндсэн дээр өөрийн үг яриаг хатуу хянах, зөв чиглүүлэх, худал үг, хэрүүл маргаан, хов жив, атаа жөтөөнөөс ангижрах, эерэг зөв, утга учиртай ярих явдал юм. Зөв сэтгэж байж зөв ярина.

Зөв үйл. Зөв үйлийн үндэс нь зөв үзэл. Хүн сайн үйл хийхийг ямагт эрмэлзэж, муу үйл бүрийг цээрлэж, бие, хэл, сэтгэлээр үйлдэх үйл бүрээ зөв байлгахыг хичээнэ. Үйл бүр өөрийн үр дагавартай. Ямар үйл хийнэ тийм л үр боловсрох бөгөөд үйлдсэн үйлийнхээ үрийг заавал амсана. Зөв үйлийн дээд нь сэтгэлийн өглөг юм.

Зөв амьдрал. Энэ нь зөв, шударгаар амьдрах явдал. Амьдрах хэрэгслээ шударгаар олж авах, амьдралаа зөв зохион байгуулах, жолоодох, бусдыг хүндэтгэх, бусдад саад болохгүй, хор хохирол учруулахгүй, тусалж, дэмжих нь зөв амьдрал. Өөртөө зөв, бусдад хүнлэг, нийгэмд өөриймсөг, ажил, хөдөлмөртөө үнэнч, байгаль, эх орноо хайрладаг байх нь зөв амьдрал юм.

Зөв чармайлт. Энэ нь зөв эргэцүүлэл, зөв тэмүүлэл. Ертөнцийн тухай, өөрийн болон бусдын талаар зөв ойлгох, мөн чанар, зүй тогтлыг нь ухаарахыг хичээн эргэцүүлэх нь зөв чармайлт юм. Муут байнга тэвчих, сайнд ямагт тэмүүлэх, түүнд хүрэхийг эрмэлзэн тэмүүлэх нь зөв чармайлт болно.

Зөв дурсан санахуй. Энэ нь зөв хандлага. Хандлага нь бодол санаа, үзэл,

үнэлгээ, итгэл үнэмшил юм. Амьдралын утга учрыг зөв ухаарах, зовлон зайлшгүй эдлэхийг ойлгох, жаргалд зөв хандах нь зөв дурсан санахуй, зөв хандлага. Амьдрал тэр чигээрээ зовлон, эсвэл үргэлжийн баяр баясгалан, зугаа цэнгэл гэж хөдлөшгүй итгэх нь алдаа гэдгийг ойлгож, ухаарах нь зөв дурсан санахуй.

Зөв бясалгал. Зөв бясалгал нь зөв төвлөрлийн үр дүн. Зөв төвлөрч байж зөв бясалгана. Ертөнцийн амьдралын хоосон чанарыг ухаарах, оюун ухаанаа зөв төвлөрүүлэн удирдах нь зөв бясалгал болно.(5.26)

“Найман гишүүнт мөр” хэмээх ёс суртахууны эдгээр зарчим нь хэн бүхний заавал биелүүлэх ёс суртахууны үндсэн шаардлага аж.

Буддагийн номлосон ёс суртахууны сургаалын өөр нэг чухал үзэл санаа нь хүний дотоодод хандсан шинжтэй сэтгэлээ судлах, удирдах, хүслээ хязгаарлан номхотгох, өөрийгөө ялж сурах, биеэ зөв авч явах, зөв үйл хийх, сэтгэл санаагаа ариусгах явдал.

Хүн биеэ зөв авч явахын тулд дараах дөрвөн хэм хэмжээг сахих ёстой гэж Будда айлджээ. Үүнд:

1. Үүсээгүй буруу үйлийг сэрэмжлэн зайлуулах;
2. Нэгэнт бий болсон буруу үйлийг таслан зогсоох;
3. Зөв үйл бий болоход тус нэмэр үзүүлэх;
4. Зөв үйлээ улам хөгжүүлэн аривжуулах;

Хүн биеэ зөв авч явахын тулд

тэвчээр хатуужилтай, уйгагүй, зүтгэлтэй, тогтмол бясалгадаг, оюун ухаанаа байнга хөгжүүлдэг, өглөгч байх гэсэн зургаан дадлыг ёс суртахууны зарчим болгон сахих ёстойг буддын сургаалд өгүүлдэг.

Хүн зан суртахуунаа хэрхэн судлах, танин мэдэх, удирдах, хөгжүүлж дэвшүүлэх арга замын талаар ч буддын ёс суртахууны сургаалд номлож, зан суртахуунаа судлах, танин мэдэх аргуудыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Буруу зан суртахуунаа шинжин тогтоох;
2. Зан суртахууны зөв хэм хэмжээг судлах;
3. Зан суртахууны мөн чанараараа өөрийгөө таних, нээх;

Зан суртахуунаа танин мэдэх гуравдугаар аргыг хэрхэн хэрэгжүүлэх талаар буддын сургаалд тодорхой заажээ. Үүнд:

- Өөрийн нинжин сэтгэлийн түвшинг тодорхойлох;
- Үүний тулд нинжин сэтгэлийн байдал төлөвийг оношлох;
- Зан төлөвийн чанаруудыг тодорхойлж, нинжин сэтгэлийн шинжүүдтэй харьцуулах;
- Нинжин сэтгэлээ ёс суртахууны шаардлагыг хангаж чадахуйц түвшинд хүргэх арга замыг судлах;
- Нинжин сэтгэл, зан төлөвийн чанаруудаа ёс суртахууны шаардлагатай түвшинд хүргэх арга замыг олох, ухааран ойлгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

Зан суртахуунаа зөв удирдан хөгжүүлэх аргуудыг ч буддын сургаалд тодорхойлсон. Үүнд:

1. Зан суртахууны язгуур чанараа сайжруулах шийдвэр гаргах;
2. Ёс суртахууны хэм хэмжээг өөртөө дадуулах;
3. Хэрэггүй юмнаас зайлсхийх, хэрэгтэй зүйлд шамдах;
4. Оюунлаг бус хүслээс ангижрахыг хичээх;
5. Амин хувиа хичээх үзэл, уур, шунал зэрэг муу сэтгэлтэй гэдгээ хүлээн зөвшөөрөх, эдгээр нь хэрэггүй, бүр хортой болохыг ухаарах;

- Муу сэтгэлийн улмаас бусдад гэм буруутай зүйл хийсэндээ чин сэтгэлээсээ харамсан гэмших;

- Бусдад туслахыг эн түрүүнд тавих. Бусдын төлөө санаа тавьж, өгөөмөр сэтгэлээр хандан туслах;

- Өөрийгөө чухалчлах, амиа бодох үзлээс салах;

- Гомдоосон, муу зүйл хийсэн хүнийг ч уучилж сурах. Зовлонтой, бухимдсан, ядарсаны улмаас ингэж байна гэж бодож, өрөвч сэтгэлээр хандах, өрөвдөх замаар уучлах;

- Өөрөө алдагаа, бусдын зөв байж болохыг хүлээн зөвшөөрөх, үйлдсэн муу үйлээ дахин давтахгүй байх замаар алдаа, дутагдлаа засаж, сэргийлж сурах;

- Хүн уурлахаараа олон алдаа хийдэг, хожим нь харамсах болдгийг байнга санах замаар уур уцаараа тэвчин дарах;

- Хомхой сувдаг зан, шунал, харамын

сэтгэлээс өглөг өгөх замаар салах;

- Залхуу хойрго зангаа бусдад туслах хүсэл, хичээнгүй зан хоёроор засах;

- Үзэн ядахыг тэвчих. Үзэн ядалт нь үзэн ядалтыг дагуулна гэдгийг хатуу ойлгох; (5.24)

Буддын ёс суртахууны сургаал нь хүн өөрийгөө өөрчлөн сайжруулах, муу муухайгаа засах, хөгжиж дэвших, зөв төлөвшихөд туслах зөв хандлага, итгэл бишрэл төрүүлэх зорилготой номлол аж. “Итгэл бишрэл нь сэтгэлийг ариусгагч, хүнийг зөв мөрт залагч юм. Сэтгэлдээ итгэл бишрэлтэй байж, сургаалын мөн чанарыг ухааран ойлгосон хүн л үйл ажлаа сайтар задлан шинжилж, бузар булайг үйлдсэндээ харамсан гэмшиж, засаж залруулахыг хичээж, сэтгэлийн гэм хир (нисваанис)-ийг арилгаж болно” (3.64) хэмээн уг сургаалд номлодог.

Гэмт, муу сэтгэлээ үгүй хийх нь сэтгэлээ илэрхийлэх болон дарахаас илүү сайн арга. Өөрийн гэмт, муу сэтгэлийг зөвтгөснөөр сайн үр дүн огт гарахгүй. Будда “Дөрвөн үнэн” сургаалдаа гэмт, муу сэтгэлийг таслан зогсоох үнэний тухай айлдсан байдаг. Таслан зогсоох үнэн гэдэг нь гэмт, муу сэтгэлийг таслан зогсоох, үгүй хийх боломж. Хүчин зүтгэх, суралцах замаар хамаг муу сэтгэлийг зогсооно, бохир усыг цэвэрлэж болдог шиг сэтгэлийг ариусгаж болно гэсэн ойлголтыг буддын ухаан олон мянганы өмнө бий болгожээ.

Сэтгэлийн гэм хирийг арилгаж ёс суртахуунлаг болох аргуудын талаар буддын сургаалд тодорхой өгүүлдэг. “Амиа бодох үзэл, уур, шунал зэрэг муу

сэтгэлтэй гэдгээ хүлээн зөвшөөрөх, ийм муу сэтгэлтэй байх нь буруу болохыг ухаарах, бусдад зовлон учруулж байсандаа чин сэтгэлээсээ харамсан гэмших, өөрийг гомдоосон хүмүүсийг ч энэрэн хайрлах, сэтгэлийн гэмт өвчнөөс ангижруулах туст эм болох оюунаа хөгжүүлэх, мунхагийг дарах, бусдыг уучлах, бусдаас уучлал гуйх нь муу сэтгэлийг засах арга гэдгийг ойлгох, муу үйлийг дахин хийхгүй гэсэн шийдвэр гаргах, түүнийгээ хэрэгжүүлэх, улам батжуулах замаар сэтгэлийн гэмийг арилгана. Эдгээр алхам сэтгэлийн гэмийг арилгаж, түүний үрийг үгүй болгоход туслана. Сэтгэлээр үйлдсэн гэмийг сэтгэл л өөрөө устгаж чадна” (2.87) хэмээн Будда сургажээ.

Буддын ёс суртахууны номлолын өөр нэг чухал хэсэг бол энэрэн нигүүлсэх сэтгэлийн тухай сургаал. Хүмүүн бид энэрүүлж, нигүүлсүүлэхийг үргэлж хүсэж, түүгээр дутагдаж явдаг. Үүний шалтгааныг буддын сургаалд:

- Нийгмийн хэм хэмжээ, дадал зуршил, итгэл үнэмшилд баригдах;
- Өөрийн үзэл санааг хамгийн зөв гэж үзэх;
- Бүх зүйл өөрийн санаснаар байх ёстой хэмээн бодох, тийм байлгах гэж зүтгэх;
- Хувиа хичээх үзэлд автах, гагцхүү “миний л зөв” гэж хатуу итгэх;
- Бусдын санаа бодлыг үл тоомсорлох;
- Өөрийн буруу байсан ч мугуйдлан туйлшрах, зөв хэмээн гэдийх;
- Өөрийгөө өмөөрч, зөвтгөх;

- Өчүүхэн шалтгаар маргах;
- Уурлах, уцаарлах;
- Бусадтай өрсөлдөх, сөргөлдөх;
- Бусдад атаархах;
- “Би” л илүү байх ёстой хэмээн бодох;
- Өс хонзон санах явдал хэмээн өгүүлжээ.

Энэрэн нигүүлсэх сэтгэлээр хандаж сурах арга замуудыг сургаалд заасан. Үүнд:

- Энэрэн нигүүлсэхэд оюун ухаанаа ашиглах. Оюун ухааныхаа хүчээр л хүмүүст энэрэн нигүүлсэх сэтгэлээр хандаж чадна;

- Бусдыг ажиглах чадвараа хөгжүүлэх. Бусдын үйлдлийг ажиглах, ажигласнаа зөв ашиглаж сурах нь нигүүлсэх сэтгэлээр хандах нэг арга зам;

- Хүмүүсийн түвшинд тохируулан харилцах. Энэ нь хүмүүсийг ялгаварлаж байгаа хэрэг бус, харин тэдний онцлогийг ойлгох, түүнд нь тохируулан харилцахыг хичээж байгаа явдал;

- Өөр биеийг үл хүндэлдэг хүнийг ч энэрэн хайрлах. Энэрэх сэтгэл хэнийг ч ялгах ёсгүй. Хүмүүсийг алагчилж, ялгахгүй хайрлаж чаддаг хүнийг энэрэнгүй сэтгэлтэн хэмээн ойлгох;

- Бусдад туслах. Ингэснээр хувиа бодох үзлээс ангижирч, бусдын төлөө явах чадвартай болно;

- Тэр зөв, энэ буруу хэмээн хатуу тогтоон хандахаас гарах уршгийг ойлгох. Хатуу байр суурь баримтлах, өөрийн санааг зөв л гэж үзэх нь бусдын эгдүүцлийг

төрүүлж, харилцахад төвөг, бэрхшээл учруулдаг;

- Эх хүн хүүхдээ буруу зүйл хийсэн ч хайрласаар байдаг шиг бусдын гаргасан алдааг уучилж, ямар ч тохиолдолд тэднийг энэрэн хайрласан хэвээр байх нь нигүүлсэнгүй сэтгэл юм; (3.62)

Буддын шүтэн барилдлагын сургаал, түүний нэг хэсэг болох үйлийн үрийн онолд ёс суртахууны хэм хэмжээг сахин мөрдөх шаардлагын тухай номлодог. Бие, хэл, сэтгэлээр муу үйл хэзээ ч хийхгүй гэсэн амыг өөртөө өгч, тангараг тавьж, түүндээ хүрэх сахил, санваар сахин мөрдөж болно. Сахил нь зөв, сайн бүхний үндэс. Сахилыг ёс суртахуун, санваарыг ёс журам гэж ойлгоно. Сахил сахихгүйгээр дахин хүн болж төрөхөд хэцүү. Эргэж хүний төрөл авах гол хүчин зүйл бол сахил, санваар сахих явдал аж.

Буддагийн номлосон сургаалыг түгээн дэлгэрүүлэх, улам баяжуулан дэвжээх үүргийг үе үеийн эрдэмт мэргэд гүйцэтгэсээр иржээ. Тэдний тоонд Төвөдийн Хөх нуурын Богд Зонхов зүй ёсоор орно.

Богд Зонхов “Сайн зарлигийн оньс бүгдийг хураасан их бодь мөрийн зэрэг” буюу “Бодь мөрийн зэрэг” зохиолынхоо “Айлдварын утгыг тодруулах” хэмээх бүлэгт “Ёс суртахуун бол номхроогүй шавийн хазаар юм. Догшин морь шиг зүтгэх буруу сэтгэлийг хазаарлан зогсоож, зөв зүгт хандуулах зүйл бол ёс суртахууны заавар журам, түүнийг хичээнгүйлэн дагавал сэтгэл хэмээх догшин морь номхорно. Сэтгэлийг номхотгоно гэдэг нь ёс суртахууны заавар журмыг дагана

гэсэн үг” (1.54) хэмээн номлож, “... бие хүний ёс суртахуун төлөвшихөд таван хорын үндсийг таслах, “би” болон “минийх” хэмээн баримтлах аминч үзлийг эн тэргүүнд орхихыг эрхэмлэх талаар өгүүүлж, тэдгээр таван хорыг тачаангуй, урин, мунхаг, омог, найдангуй хэмээн нэрлэж, тачаангуй нь хүсэл бөгөөд сайхан өнгө, эд агуурс, мал хөрөнгө зэрэгт шунаан дурлах, урин нь бусдад уурлах, хилэгнэх үйл, мунхаг нь сурч үл мэдэх, омог нь санаа буруу, өндөр хөөрүүдэн дордсыг дарлан өөрийн илүүт хөөргөх, олонд дээрэнгүйлэхийн нэр, найдангуй нь хөнгөн дөлгөөн, өчүүхэн төдий хичээхгүй, дэмий дураар балмаглан хөвхөлзөж, үг хэл, үйл, үзэл дээрээ дээд доод, хөгшин залууг үл ялгах явдал. Нэг талыг барьж туйлшрахгүй байхыг шударга гэнэ. Хүн туйлширвал түүндээ хөтлөгдөн зөв зүйтэй талыг олж харахгүй. Өөрийн үзэл бодолд хэт баригдах, бусдынхыг эс тоох, үзэн ядахыг туйлшрал гэнэ. Ийм хандлага өөрт байгаа эсэхийг ажиглаж, засаж өөрчлөх хэрэгтэй” (1.57) хэмээн тодорхойлжээ.

Богд Зонхов түүнчлэн “Хорвоогийн зовлонг буруу үйл үр, буруу үйл үрийг бузар сэтгэл, бузар сэтгэлийг “би” хэмээх мунхаг бодол тус тус төрүүлнэ гэдгийг мэдмэгц зовлонг арилгая гэсэн сэтгэл шулуудна. Муу сэтгэл зовлонд унагадаг бол сайн сэтгэл жаргалд хөтөлдөг. Арван муу сэтгэл нь шунах, уурлах, бардамнах, мунхаглах, мунгинах, өөрийнхөөрөө зүтгэх, туйлшрах, төөрөлдөх, хатуурхах, харалгантах явдал. Шунах нь хүссэн бүхэн рүүгээ тэмүүлэх, уурлах нь бүхнийг үзэн ядах, дайрч давшлах, бардамнах нь өөрийгөө дөвийлгөх, магтах сэтгэлд

хөтгөгдөх, өөрийн бодит байдлыг дэвэргэх, мунхаглах нь хүний амьдралын бодит зүй тогтлын талаар мэдлэггүйгээс болж харалган байх, мунгинах нь аливаад ялангуяа дөрвөн үнэнд эргэлзэх, өөрийнхөөрөө зүтгэх нь өөрийгөө бүхнээс дээгүүр тавих, зөвтөж зүтгэх, бусдынхыг буруу муу гэж үзэх, туйлшрах нь юмыг зөвхөн сайн, эсвэл муу, зөвхөн мөнх, эсвэл мөнх бус гэж туйлшруулах, төөрөлдөх нь туйлшруулан бий болгосон үзэл баримтлал, онол сургаалд төөрөлдөн мунхаглах, хатуурхах нь аль нэгэн дүрэм журам, ёс горимд өөрийгөө албадан захируулах, хохироох, харалгантах нь өнөөд баригдах, өнгөрсөн, ирээдүй, эх үндэсийг үгүйсгэн мунхаглах явдал” (1.256) гэж үзсэн.

Манай өвөг дээдэс буддын сургаалын сонгодог өв сан болох “Эрдэнийн сан Субашид”, “Барамидын магтаал”, “Бодь мөрийнзул”, “Бодь мөрийн зэрэг”, “Модны шастир”, “Усны шастир”, “Орчлонгийн сав шимийн дуулал”, Нагаржунагийн “Ардыг гэжээхүй дусал” болон бусад олон арван сургаалыг XIV зууны үеэс орчуулж, тайлбарлан хэрэглэж иржээ.

ДҮГНЭЛТ

Буддын сургаал хүнээс ангид орших ямар нэг хүчний тухай биш, харин хүнд өөрт нь байгаа нөөц, боломж, чадлыг нээх, зөв ашиглах, хүн өөрийгөө засаж сайжруулах, ялан дийлэх, зөвийг үйлдэх тухай өгүүлдэг тул бүхэлдээ ёс суртахууны тухай онол сургаал юм.

Буддын сургаал хүмүүсийн хүсэж байдаг тансаг орон сууц, дотор нь тавих

тохилог тавилга, хурдан унаа, үнэт эдлэл, гоё ганган хувцас хунар биш ч эл сургаал хүнийг “хүн шиг хүн”, “жинхэнэ хүн” болгох цорын ганц зөв зам мөр, хүн төрөлхтнийг байгалийн болон нийгмийн бүтээгдэхүүн болохынх нь хувьд цогцоор нь авч үздэг, ёс суртахуун, зөв хөгжил, төлөвшилийн тухай үзэл санаануудын цогц, дотоод сэтгэл, оюун ухаан руу чиглэсэн, жинхэнэ ёс суртахууны тухай үзэл баримтлал.

Буддын ёс суртахуун сургаал нь хувь хүний дагаж мөрдөх зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг боловсруулснаараа хүмүүнлэг, энэрэнгүй төдийгүй ёс суртахууныг жинхэнэ ёс журмаар нь номлодоогоороо хүн төрөлхтний ёс зүйн сэтгэлгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг аж. Буддын сургаал бүхэлдээ, ялангуяа ёс суртахууны сургаал нь хүний амьдралын бүхий л хүрээнд ямар нэг хязгаарлалт тавьдаггүйгээрээ нигүүлсэнгүй юм.

Техник, технологи “давшингуй” хөгжиж хүмүүс яаруу тэвдүү, хүлээцгүй, бухимдуу, тэвчээргүй болж, хүн чанараа улам бүр гээж байгаа энэ цаг үед ёс суртахууныг хэмжих гол үзүүлэлт тэвчээр байх ёстой гэж ёс суртахуун судлаачид, гүн ухаантнууд үзэж байна. Иймд буддын ёс суртахууны “хүлцэн тэвчихүйн сургаал”- ыг олонд өргөнөөр таниулж, дэлгэрүүлүүштэй. Хүлцэн тэвчих нь хүн, нийгэм, байгалийг хамгаалах ерөндөг, бие, хэл, сэтгэлийн гэмийг арилгах чухал арга хэрэгсэл болно.

Буддагийн номлож, түүнийг залгамжлагчдын баяжуулан дэлгэрүүлсэн сургаалууд “буддизм” хэмээх бүхэл бүтэн үзэл баримтлал болж, амьдрал практикаар

шалгагдаж, орчин үед өвлөгдөн ирсэн тул өрнөөс үүдэлтэй даяарчлалын нөлөөнд автсан бид бүхэн тэдгээрийг сайтар судлах, танин мэдэх, эзэмшин ашиглах шаардлагатай юм.

Буддын ёс суртахууны сургаал нь хүнийг сургах, хүмүүжүүлэх бүхэл бүтэн тогтолцоо юм гэж дүгнэж болохоор байна. Энэ тогтолцоог ашиглан сэтгэлээ танин мэдэх, өөрчлөн сайжруулах, оюун, сэтгэлээ боловсруулж, хөгжүүлж дэвшүүлэх боломжтой.

Буддизмыг нэг талаар ертөнцийг үзэх үзэл онол, нөгөө талаар хүнийг гэгээрүүлэх, ёс суртахуун төлөвшүүлэхэд чиглэгдсэн үзэл баримтлал гэж үзэж болно. Чухам иймийн учир зөв хөгжиж төлөвших, ёс суртахуунаа дээшлүүлэхийн тулд буддын ёс суртахууны сургаалыг судалж, танин мэдэж, ухааран ойлгож, мөн чанарт нь нэвтэрч, амьдрал, үйл ажиллагаа, харилцаандаа өргөнөөр ашиглуштай.

Буддын ёс суртахууны зарчим, хэм хэмжээг нарийвчлан тусгасан өнөөгийн нийгэм, хүмүүсийн оюун санааны хэрэгцээ, шаардлага, сэтгэлзүйн онцлогт тохирч нийцсэн ёс суртахууны боловсрол, хүмүүжлийн загвар боловсруулж, нийгмийг ёс суртахууны доройтлоос гаргахад ашиглах хэрэгтэй байна.

НОМЗҮЙ

1. Богд Зонхов. (2006). Бодь мөрийн зэрэг. Улаанбаатар, Монгол.
2. Бурхан багшийн сургаал. (1996). Япон, Токио: Косайдо.
3. Бурхан багшийн сургаал. (2005). Улаанбаатар, Монгол.
4. Данзанжамц, Д. (2007). Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй. Улаанбаатар, Монгол: Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэр.
5. Оюунчимэг, Б. (2014). Бизнесийн ёс зүй. Улаанбаатар, Монгол: Сод пресс хэвлэх үйлдвэр.
6. Оюунчимэг, Б. (2016). Буддын сургаалыг судлаж, ач тусыг нь хүртэхүй хэмээх шастир. Улаанбаатар, Монгол: DATACARD хэвлэх үйлдвэр.
7. Сонинбаяр, Ш. (2012.12.03). Бурханы шашны ёс зүйн боловсролын асуудал.

www.buddha.mn

ABSTRACT

Because religion naturally related to morale, it preaches morale thus has an influence on individual's and social morale. Every religion has very sophisticated teachings about morale and humankind has been following them. Although teaching of all religions have goals to establish single rules of morale for human kind for habituation and abidance, the buddhist teaching of morale has been continuously developed, enriched, systematized for many hundreds of years, and has become a whole concept (buddhist) and one of the most extensive teaching among other morale teachings, and its significance is becoming evermore important.

The basis of buddhist morale teaching is one should understand one's wrong feelings as diseases. Buddhist teaching see the goal of human life in close relationship with their morale. One of most important concepts of buddhist morale is avoidance from two extremes of life by following the medium path. The medium path is the union of eight appropriate paths. The other concept of morale teaching in Buddha's teaching is studying and guide one's spirit directed inward, restricting and pacifying one's desires, learning to win oneself, having a good conduct of oneself, and purifying one's thoughts and minds.

One of the most important aspect of buddhist morale teaching is about compassion. In a teaching of coorelation about requirements of following morale norm and standards, there is part about deeds and their reactions which teaches about giving promise for never committing wrong doing in one's mind, by tongue and by body, and to reach this one observe oath. Initiation is understood as morale, oath is understood as etiquette. The initiation is the basis for all.